



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ


Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ


2020 оны 6-р сар

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс: 16,123, **+1.0%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс: 7,996 **+3.4%**, **МХБ-В индекс:** 7,367 **+1.5%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.05.29	2020.06.30	Өөрчлөлт, %
DJIA (US)	25,383	25,812	1.6%
S&P 500 (US)	3,044	3,100	1.8%
Nikkei 225 (JP)	21,877	22,288	1.8%
Hang Seng (HK)	22,961	24,427	6.0%
DAX 30 (DE)	11,586	12,310	5.8%
SMI (CH)	9,831	10,045	2.1%

Валютын ханш

Валют	2019.05.31	2020.06.30	Өөрчлөлт, %
USD	2,805.97	2,823.89	0.6%
EUR	3,115.89	3,169.39	1.6%
JPY	26.18	26.21	0.1%
RUB	39.64	40.07	1.0%
CNY	392.59	399.52	1.7%
KRW	2.27	2.35	3.4%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	12.7	+285.0%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,500.5	+3.5%
Бүртгэлтэй компани	199	+1
Арилжаалагдсан хувьцаа	75	+9
Арилжаалагдсан өдөр	19	-2

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.05.29	2020.06.30	Өөрчлөлт, %
AMT	290.00	420.00	+44%
SHG	977.00	1,360.00	+39%
UID	611.00	962.17	+24%
MIK	11,000.00	12,990.00	+18%
ERDN	528.93	610.00	+15%

Зах зээлийн мэдээлэл

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 6-р сард нийт 14,011 данс нээгдсэнээс 11,056 данс шинээр, 2,955 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 11,042 дотоодын иргэн, 6 гадаадын иргэн, 8 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгджээ.

Бодь даатгал ХК-ийн IPO амжилттай болов

МХБ-ийн энэ оны анхны IPO болох Бодь даатгал ХК нь нийт хувьцааныхаа 20% буюу 47,063,944 сая ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2020 оны 05/25-ны өдрөөс 06/08-ны өдрийн хооронд авсан. Бодь даатгал ХК нь нэгж хувьцаагаа стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар 113 төгрөгөөр, олон нийтэд захиалга бүртгэлийн аргаар буюу 113-135 төгрөгийн хооронд санал болгосон. Үнэт цаас гаргагч нь нийт 5.3-5.6 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба нийт 959 хувь хүн, аж ахуйн нэгж нийт 5,318,225,672 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх доод дүнг 100% хангасан үзүүлэлт болжээ. Захиалга бүртгэлийн аргаар хуваарилах эцсийн үнийг нийт захиалгад ирүүлсэн үнэ болон татан төвлөрүүлэх үнийн дүнг харгалзан 113 төгрөгөөр тогтоосон байна. Бодь даатгал ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг хөрөнгө оруулалт, инноваци технологийн хөгжүүлэлт, сайжруулалтанд зарцуулах юм.

ЛэндМН ХК 5.0 тэрбум ₮-ийг нээлттэй бондоор босголоо

ЛэндМН ХК өөрийн хувьцаагаар баталгаажсан, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17 хувийн хүүтэй өрийн хэрэгсэл буюу бондыг 2020 оны 6-р сарын 15-наас 19-ны хооронд МХБ-ээр олон нийтэд нээлттэйгээр арилжиж, 5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлжээ. Нийт 528 иргэн, аж ахуйн нэгжээс нийт 67,424 ширхэг буюу 6,742,400,000 төгрөгийн үнийн дүн бүхий захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 34.8%-аар давсан дүн болов. Захиалгын хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 28.8 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100% биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг 58.8%-аар хувь тэнцүүлэн хуваарилсан байна.

Сүү ХК нэмэлт хувьцаа гаргана

Сүү ХК-ийн нийт хувьцааны 19.92%-тай тэнцэх 85,589,000 ширхэг хувьцааг (18.7 тэрбум ₮) нэмж гаргах саналыг СЗХ-ноос 6-р сарын сүүлээр болсон хурлаараа хэлэлцэж зөвшөөрсөн байна. Шинээр нэмж гаргах хувьцааны нэгж үнийг 218 төгрөгөөр тогтоож, 77,030,100 ширхэг хувьцааг (16.8 тэрбум ₮) стратегийн хөрөнгө оруулагчдад, 8,558,900 ширхэг хувьцааг (1.9 тэрбум ₮) олон нийтэд санал болгон, анхдагч зах зээл дээр арилжихаар төлөвлөжээ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-аас ирүүлсэн өрөмдлөгийн мэдээлэл

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци /MSE:ERDN/ нь Баян Хөндий Алтны Төслийн тусгай зөвшөөрлийн талбайд эхлүүлсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн тухай МХБ-д мэдээлэл ирүүлсэн нь уг өрөмдлөгийн хөтөлбөр хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилагдсан бүсүүдийн эрдэсжилтийг шалгах зорилготой байсан ч алтны агуулгатай шинэ бүсийг илрүүлсэн тухай байв. Үүнтэй холбоотой тус

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2020.05.29	2020.06.30	Өөрчлөлт, %
AOI	1,700.00	1,125.00	-33%
NXE	2,400.00	1,900.00	-20%
BDS	1,013.00	861.00	-15%
DRU	650.00	560.00	-13%
ONH	1,390.00	1200.00	-13%

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн. сая төг	Эзлэх %
MMX	228,090	551.9	4.3%
AIC	520,472	364.3	2.8%
LEND	7,535,965	234.0	1.8%
APU	279,194	151.2	1.1%
MNP	111,407	66.8	0.5%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2020.06.30	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
AMT	4.5	2.0	+44.8%
SHG	9.9	3.8	+39.2%
UID	22.4	5.5	+24.7%
MIK	227.8	41.2	+18.0%
ERDN	2.1	0.324	+15.3%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2020.05.29	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
AOI	3,932.5	1,330.1	-33.8%
NXE	3,092.4	644.2	-20.8%
BDS	17,221.0	2,584.0	-15.0%
DRU	197.4	27.3	-13.8%
ONH	155.5	21.2	-13.6%

компанийн ханш ТХБ дээр 6-р сарын турш өсч, 0.28 CAD-с 0.39 CAD (+39%) болсон бол МХБ дээр 546.67₮-с 610₮ (+12%) болж өссөн байна.

Улсын их дэлгүүр ХК-ийн барилгад гарсан түймрийн тухай

УИД ХК-ийн барилгад 2020 оны 6-р сарын 7-ны өдөр гал гарч, барилгын дээд давхрууд шатаж, томоохон гарз хохирол тохиолдсон. Гал түймэр гарсан шалтгааныг шинжээчид дүгнэсэн ба дүгнэлтээр тус барилга дээр дээврийн ажил хийж байсан Ай Ти Эн ХХК-ийн ажилчид хар цаасыг халааж, хайлуулан наах ажил хийх явцдаа гал алдаж, гал түймэр гарахад хүргэсэн гэж тогтоожээ. УИД ХК нь Номин даатгал ХХК-тай “Үл хөдлөх хөрөнгийн даатгал”, “Байгууллагын хариуцлагын даатгалын гэрээ”-г тус тус байгуулсан байжээ.

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тухай

Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.4-т заасны дагуу хувьцаат компанийн ТУЗ нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 5-р сарын 1-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулах үүрэг хүлээдэг. СЗХ-нд бүртгэлтэй нийт хувьцаат компаниудаас 163 хувьцаат компани 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай хурлын мэдэгдлийг ирүүлсэн бөгөөд 136 хувьцаат компани Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр холбогдох материалыг Хороонд ирүүлж, 4 хувьцаат компанийн хурал хойшлогдож, 23 хувьцаат компани хувьцаат компанийн хурлын шийдвэр, холбогдох материалыг ирүүлээгүй байна.

Та цахимаар дансаа нээж, арилжаа хийхийг хүсвэл манай “Цахим данс” системд бүртгүүлээрэй. Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайнар дансаа нээж, арилжаа хийх боломжтой.

“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ



<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 6-р сарын эцэст 21.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 966.0 (4.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 1.4 (47.1%) их наяд төгрөгөөр, валютын харилцах 105.4 (4.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 6-р сарын эцэст 987.3 тэрбум болж, өмнөх сараас 13.2 (1.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 50.2 (5.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.06	2020.06*
Мөнгө M2	20,229.4	21,995.4
Бага мөнгө M1	4,104.5	3,568.9
Төгрөгийн харилцах	3,451.7	2,876.9
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	652.7	692.0
Бараг мөнгө	16,124.9	17,626.5
Төгрөгийн хадгаламж	10,936.4	10,949.8
Валютын хадгаламж	2,932.8	4,315.6
Валютын харилцах	2,255.7	2,361.1
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	937.1	987.3

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 6-р сарын эцэст 17.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 187.4 (1.1%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 845.3 (4.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 6-р сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 138.5 (12.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 256.0 (394.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 6-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 53.2 (2.7%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 5.0 (0.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зургаг 29. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.4 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 4.1 их наяд төгрөг болж нийт орлогын 94.1 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.



Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны 5-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 869.4 сая ам. долларын алдагдалтай гарч, алдагдал нь өмнөх оны мөн үеэс 378.0 (76.9%) сая ам. доллараар өсчээ. Урсгал данс 869.4 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 568.9 сая ам. доллар, анхдагч орлогын данс 260.0 сая ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зургаг 36. Урсгал данс, сая америк доллароор, сараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эхний хагас жилд нийт 135 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.3 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 2.8 тэрбум ам. доллар, импорт 2.5 тэрбум ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 (22.6%) тэрбум ам. доллар, үүнээс экспорт 1.1 (28.2%) тэрбум ам. доллараар, импорт 433.7 (15.0%) сая ам. доллараар тус тус буурчээ.

Зургаг 37. Экспорт, импорт, тэнцэл, сая америк доллар




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны энхний хагас жилд 1.0 тэрбум ам. долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 677.0 сая ам. доллараар буурч, 368.2 сая ам. долларын ашигтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 6-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны эцсээс 2.7 хувь, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн байна.

Зургаг 41. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 6-р сард өмнөх оны мөн үеэс 2.8%-р өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.3% (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5.0%, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.1%), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.6%, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.4%, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3% (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 3.0%), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.0%-р өссөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 7.2%-р буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо
АвтоХаб төв, 1-2 давхар

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2020 *Стандарт инвестмент ҮЦК*